



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 1/143

Мандалговь

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 70, 71, 72, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Аймгийн Засаг даргын тамгын төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Э.Одончимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүн: Ц.Даваа (Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Цэрэндолгор (Цэргийн штабын тоо хариуцсан офицер)


С.Цэнгэлмаа (Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Мөнгөн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэдээлэл харилцаа технологийн асуудал хариуцсан ажилтан)

Б.Жаргалсайхан (Үйлчилгээний алба, цахилгаанчин, мужаан)

2. Байгууллагын эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журмын дагуу 2022 оны 06 сарын 15-ны өдрийн дотор дуусгавар болгож үр дүнг тооцон Тамгын газрын даргад тайланг нэгтгэж хүргүүлэхийг комиссын дарга (Э.Одончимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



1022150341